



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 03 дугаар сарын 27

№ 01/85 ДУА - 2018/2/СТА - ОНӨААИ/Мандалговь хот

Г

Г

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад 5,607,790.00 /Таван сая зургаан зуун долоон мянга долоон зуун ерэн/ төгрөгийн насжилт өндөртэй авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.5-д /дансны өглог, авлага ба өр төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрхзүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй, үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглогийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Насжилт өндөртэй авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын дарга Д.Ганбаатар, нягтлан бодогч Л.Сүрэндолгор нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:



АУДИТОР

ӨГСӨН:

Ж.УГТАХБАЯА

ДАРГА

Д.ГАНБААТАР

НЯГТЛАН БОДОГЧ

Р.СҮРЭНДОЛГОР

¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанг хүргүүлнэ.